

“МҮГДЭНГИЙН МОНГОЛ СЭТГҮҮЛ”-ИЙН ТУХАЙД

Л.Норовсүрэн\*

\* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, шинжлэх ухааны доктор (Sc.D.), МУИС-ийн профессор

**Түлхүүр үг:** аман болон бичгийн нийтлэлийн түүхэн уламжлал, “Мүгдэнгийн монгол сэтгүүл”, цахилгаан мэдээний булан.

**М**онголд сэтгүүл зүйн сургалт, судалгаа эхэлснээс хойших 45 жилийн үр дүнгийн нэг нь Монголын нийтлэл, сэтгүүл зүйн түүхэн туршлагыг бараг долоон зууныг хамран судалж, нэгтгэн дүгнэсэн явдал мөн. Энэ судалгаа нь монголчуудын мэдээллийн харилцааны эртний хэлбэрүүдээс эхлээд XIII-XIX зууны аман болон бичгийн нийтлэлийн түүхэн уламжлал, XIII-XIX зууны аман болон бичгийн нийтлэлийн түүхэн уламжлал, XIX-XX зууны зааг үед гадаад орнуудаас Монголд зориулан гаргаж байсан тогтмол хэвлэлүүд, XX зууны эхэн үеэс үүссэн үндэсний дэвшилт ардчилсан сонинууд, улмаар хувьсгалт хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд, өнгөрсөн зууны ерээд оноос эхтэй чөлөөт ардчилсан сэтгүүл зүйн түүхэн туршлагыг багтааж байгаа юм. Гэвч энэ

нь Монгол хэмээх нэгэн тусгаар улсын хамааралтай судалгаа юм.

Сэтгүүл зүйн түүхийн судалгааг дан ганц Монгол улсын хүрээнд бус, нийт монгол үндэстний хэмжээнд хүртэл өргөжүүлэн явуулснаар монгол туургатны хэвлэлийн түүхийн судалгааг иж бүрэн болгох хоёрдахь шатны зорилт хэрэгжих учиртай юм. Энэ зорилгын үүднээс авч үзвэл монгол үндэстний нийтлэл, сэтгүүл зүйн түүхэнд хоосон орон зай багагүй байгаа юм. Ялангуяа Монгол улс хэсэг бусгаараа удаа дараалан Манжийн эрхшээлд орж, ар өвөр хэмээн хуваагдаж, XX зууны эхэн үеийн үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөөх тэмцэл, хувьсгалт хөдөлгөөн зэргийг дайрч өнгөрсөн түүхэн замналын явцад монгол хэлний олон сонин хэвлэлийн дурсгал үрэгдэж, тэдгээрийн талаарх мэдээлэл улам бүдгэрсээр байгаа билээ. Одоогоор бараг зуугаад жилийн тэртээ монгол хүн, монгол хэлээр гаргаж байсан “Нялх”, “Илийн ер үгийн сонин” зэрэг тогтмол хэвлэл өнөөдөр ор тас мартагдахад

хүрч, мөн тэр үед гарч байсан "Монгол утгын сэтгүүл" зэрэг тогтмол хэвлэлийн талаарх мэдлэг ч бас л хомсхон байсаар.

Бодит сэтгүүл зүйн гэрч баримт болсон энэ мэт сонин, сэтгүүлийн үзэл баримтлал, улс төрийн чиглэл, нийтлэлийн агуулгыг судалж эрдэм шинжилгээний эргэлтэд оруулахад нийт монгол үндэстний эрдэм шинжилгээ, сургалтын байгууллагын хүчин чармайлтыг нэгтгэн дайчлах шаардлага гарч байгаа билээ. Энэ ажлын эхлэл ямар нэг хэмжээгээр тавигдсанд судлаач миний бие баяртай байна.

2005 оны хавар манай НШУС-иас БНХАУ-ын Өвөр Монголын их сургуулийн Монгол судлалын сургуультай байгуулсан хамтын ажиллагааны гэрээнд "Нийт монгол үндэстний хуучин тогтмол

хэвлэлийн түүхийн судалгаа"-г хамтран хийж, ном бүтээх заалт тусгагдсан нь дээрх зорилтыг хэрэгжүүлэхэд томоохон түлхэц болно хэмээн найдаж байна. Уг ажлын эхлэл болгож та бүхэнд, Ар, Өвөр Монголын аль алинд нэгэнт олдохгүй байсаар ирсэн нэгэн сонины тухай товчхон мэдээлье гэж бодож байна.

"Мүгдэнгийн монгол сэтгүүл" хэмээх энэ сонин тухайн үед Зүүн хойт Хятадын гурван мужийн нэг болох Лионин мужийн

Шинь Ян хот буюу монголчуудын нэрлэж заншсанаар Мүгдэнд гарч байжээ. Уг сонины талаар Ар, Өвөр Монголын сэтгүүл зүйн түүх судлаач эрдэмтэд ямар ч тодорхой мэдээлэлгүй байсан билээ.

Гэтэл өнгөрсөн хавар миний бие Өвөр Монголын их сургуульд зочин профессороор очиж лекц унших явцад Японы Токиогийн их сургуулийн профессор, монгол судлаач Футаки Хироши багш "Мүгдэнгийн монгол сэтгүүл"-ийн долоон дугаарын хуулбар

хувийг Өвөрмонголын их сургуулийн Сонин мэдээний тэнхмийн эрхлэгч Учралтад ирүүлээд байсантай тааралдаж ихэд олзуурхан авч үзсэн билээ. Тэр илгээмжид уг сонины 1918 оны 15, 16, 1919 оны 56, 57, 58, 62, 63 дугаар багтсан байв. Энэ сонины байнгын эле-

мент буюу толгойн хэсэгт "Сэтгүүл гаргахыг тогтсон өдөр: нэг долоон хоногт нэг удаа гаргамай. Тус сэтгүүлийн үнэ: Нэг хуудас зэс зоос таван төгрөг, нэг сард хоёр зуугаар бодмой. Дэлгэрүүлэн гаргах зоос нэг өдөр нэг сун дөрвөн юан, хэрэв үүрд гаргаваас дахиж хэлэлцмой. Гаргах жич зохиогч хүмүүн: Жиүй чи жен эл, Үсэг дарагч хүмүүн: Ми диян Си Фин, Гаргах газар: Мүгдэнгийн их баруун хаалганы дотор буй "Монгол сэтгүүлийн

«

*Одоогоор бараг зуугаад жилийн тэртээ монгол хүн, монгол хэлээр гаргаж байсан "Нялх", "Илийн ер үгийн сонин" зэрэг тогтмол хэвлэл өнөөдөр ор тас мартагдахад хүрч, мөн тэр үед гарч байсан "Монгол утгын сэтгүүл" зэрэг тогтмол хэвлэлийн талаарх мэдлэг ч бас л хомсхон байна.*

»

хүрээ" гэсэн дармал байна. Энэ мэдээллээс зарим зүйлийг тодруулж болохоор байна. Тухайлбал уг сонин долоо хоног тутам гарч байсан гэж үзвэл эхний дугаар нь 1918 оны 8 дугаар сарын дунд хэрд гарсан байх бололцоотой юм. Бидний олж үзсэнээр тус сонин үүссэн өдрөөсөө хойш 1 жил 2 сар гаруй хугацаанд 63-н дугаар гаргасан байна. Харин сонин хэдийд гаралтаа зогсоосон, нийт хичнээн дугаар гаргасан тухай баримт одоогоор олдоогүй байна. Дээрх мэдээллээс бас уг сонин жижиглэн борлуулах, тодорхой хугацаанд захиалж унших, байнга авах зэрэгт тус тусын уян хатан үнэ тогтоодог байсныг мэдэж болох юм.

"Мүгдэнгийн монгол сэтгүүл" ерөнхийдөө дэвшилт үзлийг номлож, үндэсний тусгаар тогтнолын төлөө санааг эрхэмлэсэн улс төр, танин мэдэхүйн чиглэлтэй сонин байжээ. Сонины нийтлэлийн ноён нурууг Орос, Дундад иргэн улсын харилцаа, тэдгээрээс монголчуудын талаар баримталж буй бодлого, үйл ажиллагаанд шүүмжлэл дүгнэлттэй хандсан цуврал өгүүллүүд босгох бөгөөд олон улсын байдал, Дундад иргэн улсын улс төрийн амьдрал, монгол хошуудын ард олны амьдрал ахуйг тусгасан товч, шуурхай мэдээ зонхилох хэсгийг эзэлдэг байжээ.

Тус сонинд мэдээ нийтэлж байсан арга хэлбэр нь тухайн үед Нийслэл хүрээнд гарч байсан "Шинэ толь хэмээх бичиг", "Нийслэл хүрээний сонин бичиг"-үүдийнхтэй адил байгаа нь сонирхол

татах бөгөөд, тэр үед нийт монголчууд сонин сэтгүүл гаргах нийтлэг дэг сургуультай байж үү дээ гэсэн бодол төрнө. Сонин бүх мэдээгээ "Цахилгаан мэдээ", "Дотоод гадаадын чухал сонсгол", "Аливаа сонсгол" гэсэн тогтмол гурван буланд төрөлжүүлэн нийтэлдэг байсан бөгөөд энэ гурван булан улс төр, нийгмийн амьдралын бүхий л үйл явдлыг хамарч чаддаг байжээ.

**Ц**ахилгаан мэдээ булангийн олонх мэдээ оноосон нэргүй бөгөөд үлгэрлэвэл "У Ивү-гийн цахилгаан", "Бээжингийн цахилгаан", "Зүүн нийслэлийн цахилгаан", "Бас цахилгаан", "Тодорхой сонсгох нь" гэх мэт гарчигтай байв. Харин "Дотоод, гадаадын сонсгол" буланд тодорхой тайлбар үндэслэл бүхий нэлээд дэлгэрэнгүй мэдээ нийтэлдэг байжээ.

Тус буланд бас ихэс дээдсээс улс төрийг засах явдалд холбогдуулж сонинд ирүүлсэн шүүмжлэлт бэсрэг өгүүлэл, захидлыг нийтэлдэг байв. Иймэрхүү ноцтой асуудал хөндсөн материалыг сониныхон нэлээд болгоомжтой, тодруулбал зохиогчийн нэр зааж нийтэлдэг байсныг "Хишигтэн хошууны гүн Ролгаржав багшийн илгээсэн эх зохиолыг ёсоор хуулан гаргавай" гэсэн гарчигтай зүйл харуулж байна. Тэр захидалд Эрх мэдэлтнүүд улс төрийг засахдаа ард олны эрх ашгийг огт бодохгүй байгааг шүүмжилж "Мөн ч ертөнцийн ёсоныг тааж, хүний гол ёсоноор явах болбаас хэрхэн өршөөлт засгийг явуулах эрдмээр соёл

засахыг хэрэглэхгүй болон чадах ажээ. Энэ мэт явдлыг хичээн ухахгүй агсаар нэгэн цагт мөнхдөлгүй алдаш гарч, огтхонч тэнхрүүлбээс үл болохуй дор хүрсний хойно авгай нар ч бас бие, хэр чинээ бүрэн бүтэн болгож, хойч үед буян хишгийг эгүр болгон чадах буюу. Энэ нь даруй зэвсэг барьж хүмүүнийг чичиж алаад, бас бус зэвсэг хэмээхээс юун өөр буй” гээд “Эртхэн эрдэм соёлыг бадруулан, өршөөлт засгийг явуулж, угсаа аймаг дороо тустайг үйлдвээс сая бидний урьд өвөг Богд Чингис хааны шалгарсан гайхамшигтай гэгээн алдрыг дахин гэрэлтүүлж чадахуй хэмээх төдийгүй, харъяат олны эгээрэн үзэхийг алдахгүй, гавъяа нэр түмэн үед дуурсах болой” гэсэн байна.

**Т**ус сонины “Аливаа сонсгол” буланд нийтэлдэг шинжлэх ухааны танин мэдэхүйн зорилготой тайлбар мэдээнүүдийн зарим нь манай ууган тогтмол хэвлэл “Шинэ толь хэмээх бичиг”-ийнхтэй бараг үг, үсгийн зөрөөгүй тохирч байгаа нь тэр үеийн монгол сэхээтнүүд байгаль ертөнцийн зүй тогтлыг шинжлэх ухааны үүднээс тайлбарласан нэгэн номыг ашиглаж шинжлэх ухааны суртал нэвтрүүлэг хийдэг байсан болов уу гэх таамгийг төрүүлж байгаа юм.

Тухайлбал тус сонины “Элдэв ухааныг бадруулан нэвтрүүлэх нь” гэсэн зүйлийн тавдугаарт байгаа “Хүйтэн, халуун, салхи, өвөл, хур бороо, цас тэргүүтний учир” гэсэн гарчиг болон түүнд өгүүлсэн “Манай бөөрөнхий

дэлхий дээр нарны гэрэл хэдүй эгц тусваас төдий халуун байх тул зэргээр халуун, сэрүүн, хүйтний улиралт орон хэмээн ялгамуй. Мөн халуун, хүйтэн хоёрт шүтэж салхин хөдлөх, салхинд дагагдаж үүл явах, сэрүүнээс үүлэн доторх усны уур нийлэлдэж борооны дусал болон буух ба хүйтнээс усны уур нийлэлдэн хөлдөж цасан болж унамой” гэхчилэн байгаль цаг уурын үзэгдлийн учрыг тайлбарласан зүйл арвин байна.

“Мүгдэнгийн монгол сэтгүүл” сонин нийтлэлийнхээ ноён нуруу болсон томоохон өгүүллүүдийг “Шүүмжлэл өгүүлэл” гэсэн тогтмол булангийн дор цувралаар нийтэлдэг байжээ. “Монголын засаг явуулах дүрмийг түргэн халан сайжруулбаас зохимой”, “Манай монголчууддаа чин үнэн сэтгэлээр сонсох үг”, “Монголын тарианы улсаас гааль авах дүрэмд оруулан шийтгэхээ болзсон цаазнаа үл нийлэхийг шүүмжилмой”, “Монголын атар газрыг хагалбарлах засгийн яамны бодлого” зэрэг томоохон өгүүллүүд энэ буланд нийтлэгджээ.

1919 оны 58 дугаарт нийтлэгдсэн “Монголын засаг явуулах дүрмийг түргэн халан сайжруулбаас зохимой” гэдэг асуудал дэвшүүлсэн өгүүлэлд таван угсааны иргэд тэгш эрхтэй гэсэн Дундад улсын цааз хэрэгжихгүй, монгол аймаг, хошууд аливаад захчлагдан буйг эсэргүүцэж, хятад иргэдтэй адил эрхтэй болгохыг шаардсан агуулгатай юм. Уг өгүүлэлд монгол газрыг хөгжүүлж баян чийрэг болгох хэд хэдэн чухал санал дэвшүүлсэн юм. Тухайлбал “Манай

монгол газарт үнэхээр их гаралт ахуй болой. Морь мал, хонь тэмээ тэргүүлэн элдэв зүйлийн арьс үс ба ун тариа, уртын бодис цөм бүрдэж, энэ дээр адуу мапаар нэн нэр алдаршсан биш үү. Эдгээрийг цөм өөрийн эд болгон хийж чадаад гадагш худалдаж, өөрөө эдлэх болбаас энэ даруй их ашиг болой. Хэрэв аливааг үүсгэн хийх эрдэм ухаанаар гачигдваас тариа тарихыг хятадаас сурч, бусдыг утга гэгээн гадаад улсаас асуун суртугай. Нэн тэр Жи бен улсын удсангүй хэдэн арван жилийн хооронд баян түрэмгий болсныг дуурайваас зохимой” гэх буюу “Газар орныг засан, хүмүүн иргэний эрх ашгийг хамгаалж, гадаад лугаа хэрэг шийтгэхэд адил зэргийн гол ёсоныг олон чадваас үүнийг сая энэ утга гэгээн ертөнцийн дээр нэгэн аймаг бүрэн бүтэн хүмүүн иргэн хэмээмой. Манай Монгол эдүгээ Дундад улс таван төрлийн дотор орж, нүдний өмнө гадаад улс лугаа харилцан явалцмаар хэрэг үгүй. Гагц Хятад лугаа явалцах нь маш үлэмж. Ойр хэдэн оноос Дундад засгийн яамнаа Монголыг онцгойлон зочлох хугацаа дор буй бөгөөтөл Монгол хошуудаар хэрэг бүрт адил зэргийн эрх ашгийг олж чадсан нь

маш цөөн... Монгол, хятад дарга, түшмэл өнөө бас Монголын тариаг тэгшлэн, Монголын гаралт хөрөнгийг байцаан, үнэ тогтоож, гааль авах хэлэлцлэг буй. Үнэхээр үнэн хэрэг болох болбаас энэ бас манай Монголын их ашиг бус хэрэг болой. Монгол хүмүүн анхнаас ашиг олох замыг гүнээ мэдэхгүй, түүний хөрөнгийг энэ мэтээр татлан авах болохул түүний үгүйрэх нь удахгүй болжухай” гэхчилэн бичээд эдгээр урагшгүй явдлын шалтгаан нь даруй засаг явуулах дүрмийн муугаас болсныг цохон заажээ. Тус сониныхон бас 1919 онд гарсан “Дундад иргэн улсын илэрхий цааз” нэртэй үндсэн хуулийн эхийг нийтэлж, олон иргэдийн саналыг авах ажил зохиож байсан нь нэн дэвшилттэй юм. Уг цаазын, хүний эрхтэй холбогдсон зарим заалтыг сийрүүлбэл “Аравдугаар зүйл: Дундад иргэн улсын хүмүүн иргэнд үг шүүмжлэл ба бичиг зохиох, жич дармаллан гаргах өөрийн дурын эрх буй. Цаазаар бус болохул хэмжээлэн захирахыг хүлээхгүй. Арванхоёрдугаар зүйл: Дундад иргэн улсын хүмүүн иргэний эд хөрөнгийн эрх бүхий газраа булаан халдахыг хүлээхгүй. Арвангурав-

«  
*“Мүгдэнгийн монгол сэтгүүл”  
сонин нийтлэлийнхээ ноён нуруу  
болсон томоохон өгүүллүүдийг  
“Шүүмжлэл өгүүлэл” гэсэн  
тогтмол булангийн дор цувралаар  
нийтэлдэг байжээ. “Монголын  
засаг явуулах дүрмийг түргэн  
халан сайжруулбаас зохимой”,  
“Манай монголчууддаа чин үнэн  
сэтгэлээр сонсох үг”, “Монголын  
атар газрыг хагалбарлах засгийн  
яамны бодлого” зэрэг томоохон  
өгүүллүүд энэ буланд  
нийтлэгдэжээ.*

»

дугаар зүйл: Дундад иргэн улсын хүмүүн иргэнд цаазаар зарга заргалдлага хийж, хүсэх эрх ба гуйн хүсэх эрх буй.

Арвандерөвдүгээр зүйл: Дундад иргэн улсын хүмүүн иргэнд цаазаар сонгон өргөх ба сонгон өргөгдөх эрх буй” гэх мэт олон эрхийг хуульчлан заажээ.

“Мүгдэнгийн монгол сэтгүүл” хэмээх сонины томоохон өгүүллүүдийг Боржигон Буянмандах, Симинов Далай, Ваншингэ, Бирагадуй нарын зэрэг хүмүүс бичдэг байв. Ялангуяа Боржигон Буянмандахын бичсэн өгүүллүүд улс төрийн бодлогын талаар хурц асуудал хөндөж, зоримог шүүмжлэл өрнүүлдэг, хүний сэтгэлд хүрэхүйц цэгцтэй, яруу үг хэлээр бичигддэг шинжээрээ гойд ялгарч байна. Тэрбээр “Мүгдэнгийн монгол сэтгүүл”-ийн 1918 оны 16 дугаарт нийтлүүлсэн “Манай монголчууддаа чин үнэн сэтгэлээр сонсгох үг” гэдэг өгүүлэлд “Газрын бөмбөцөг гэгч агуу их. Тогтнож бүхий улсуудыг тоолбаас тавин тивийн дотор хэдэн арав бий. Түүний дотор баян түрэмгий ба үгээгүй дор, эрдэм ухаантай, зэрлэг мунхгийн ялгавар тус тусдаа адилгүй” хэмээн нэн ойлгомжтой өгүүлсэн бол, 1919 оны 62 дугаарт нийтлэгдсэн “Монголын тарианы улсаас гааль авах дүрэмд оруулан шийтгэхээ болзсон цаазнаа үл нийлэхийг шүүмжилбэй” гэдэг өгүүлэлд “Илүү нь дийлмой, дутуу нь дийлдмой. Түрэмгий нь тогтномой, буурай нь буснимой. Юуны гол ёсон хэмээмой, юуны өршөөл журам хэмээмой” гэж улс үндэстний тэгш бус эрхийг шүүмжлэн бичсэн байна.

“Мүгдэнгийн монгол сэтгүүл” Монгол, Хятадын ард түмэн Манж Чин гүрний ноёрхлыг түлхэн унагаасны дараа Зүүн хойт хятадын нутагт гарч байжээ. Энэ үед хэдийгээр үндэсний хувьсгал гарсан ч Өвөрмонгол Дундад улсын мэдэлд хэвээр үлдсэн юм. Тэд Ар монголтой нэгдэх хүсэлтээ удаа дараа илэрхийлж “Өвөрмонголын хошууны олон бид нар Халх монгол лугаа үндсэн язгуур нэг тул хэдий нийлүүлэхгүй гэвч толгой хагарсан ч нийлнэ хэмээн зүтгэнэ. Монгол улсын зах хязгаарыг эртнээс журамлаж ирсэн тодорхой тэмдгээр тогтоож өг” хэмээн Монгол улсын хурлын газарт өргөдөл ирүүлж байх үед уг сонин гарч байсан нь санамсаргүй хэрэг биш ажээ. “Мүгдэнгийн монгол сэтгүүл”-д Дундад улсын Засгийн газар хот суурин байгуулах, газар тариалан хөгжүүлэх нэрийдлээр Өвөр монголын нутагт хятад иргэдийг олноор суурьшуулж, газар нутгийн баялгийг цөлмөж, хүн ардын эрхийг хязгаарлаж байгааг эсэргүүцэн шүүмжилсэн агуулгатай нийтлэл тус сонинд цөөнгүй байна.

**Т**ус сонин цаг үеийн үйл явдлыг нэн шуурхай мэдээлдэг байсан бөгөөд “өчигдөр”, “өнөөдөр”, “өнөө өглөө үүрээр” гэх мэтээр болсон явдлын цаг хугацааг заадаг байсан нь сонирхол татаж байна. Сонин фото болон зураасан зураг, чимэглэлийн элементүүдийг бараг хэрэглэдэггүй байжээ. Гагцхүү улс төрийн үйл явдалд гол анхаарлаа хандуулж, тэдгээр үйл

явдал монголчуудын амьдрал, хувь заяанд хэрхэн холбогдож байгааг тайлбарлаж, монгол үндэстний эрх чөлөө, сэргэн мандлын төлөө тэмцэж байсанд "Мүгдэнгийн монгол сэтгүүл"-ийн ач холбогдол оршиж байжээ.

#### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Д э л э г Г. 1965. Монголын тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ.
2. Д э л э г Г. 1972. Монголын хэвлэл. УБ.
3. Д э л э г Г. 1971. Монголын хэвлэл. УБ.
4. Н о р о в с ү р э н Л. 2000-2003. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. УБ. 1-3-р боть.

5. Н о р о в с ү р э н Л. 2004-2005. Монголын нийтлэл. УБ. 1-2-р боть.

#### Резюме

В статье рассматриваются проблемы публикации "Мукденского монгольского журнала", который выпускался в Мукдене — городе Шинь Ян провинции Лионин, — с августа 1918 года на протяжении 1 года и 2 месяцев. До сих пор монгольское журналистиковедение и не подозревало о существовании прессы с таким названием, которая выпускалась на монгольском языке.